



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар A/19

Улаанбаатар хот

Ажил гүйцэтгүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 3.1.1, 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын эрх ашиг сонирхлын дагуу бүхий л талын хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэхийг энэ салбартаа мэргэшсэн хуулийн зөвлөх болох “НЬЮ ГРАТА Жи Эл Пи Ви” ХХК-аар гүйцэтгүүлсүгэй.

2. “НЬЮ ГРАТА Жи Эл Пи Ви” ХХК-тай хамтран ажиллах гэрээний дагуу шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг Ерөнхий инженер бөгөөд барилга байгууламжийн инженер Г.Пүрэвдоржид, сар бүрийн ажлын гүйцэтгэлийг дүгнэж ажиллахыг Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн А.Нямхүүд тус тус үүрэг болгосугай.

3. Хамтран ажиллах гэрээний дагуу тухайн сарын ажлын гүйцэтгэлийн тайланг эрх бүхий этгээдээр гарын үсэг зуруулж, дүгнүүлсний дараа төлбөрийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч Г.Батнямд зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү, төлөвлөлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Алтан-Очирт даалгасугай.

ДАРГА  М.ГОНЧИГЖАВ

3150600019